

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ГАЗРЫН СҮЛЖЭЭНИЙ ДЭД БҮТЦИЙН ХЭЛТСИЙН
БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН, ШУУДАНГИЙН ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ШАРАВЖАМЦЫН САМДАНЖАМЦЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

Зорилт 1. Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, хяналт тавина.							
1.	Арга хэмжээ - 1.1. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх шинэ болон шилжих төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах.	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	50%	“Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ”-ний тушаалын төслийг хавсралтын хамт боловсруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/12 дугаар тушаалаар батлуулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 сарын 26-ны өдрийн А/45 дугаартай тушаалаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулж, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.	01-06 сар	90%
	Дэд арга хэмжээ - 1.1.1. Сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, батлуулах.	Батлуулсан төлөвлөгөөний тоо	1	1	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тушаалын төслийг хавсралтын хамт боловсруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг батлуулсан.	01-06 сар	100%

	Дэд арга хэмжээ - 1.1.2. Үнэлгээний хороодыг байгуулах, тендерийн баримт бичгийг боловсруулах, батлуулах, тендер, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах.	Байгуулсан үнэлгээний хорооны тоо	0	8	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ"-ний хүрээнд "Сангийн хөрөнгөөр сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргах" ЦХИХХЯ/20250203003, "Харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ хүрээгүй хүн ам, газар нутгийн талаарх зах зээлийн нөхцөл байдлын судалгааг хийлгэх" ЦХИХХЯ/20250203004, "Алслагдсан багт харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, шинэчлэх, өргөтгөх арга хэмжээг зохион байгуулах" ЦХИХХЯ/20250203006, "Харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг алслагдсан бүс нутагт турших, нэвтрүүлэхэд шаардлагатай нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмж (30 цэг)" ЦХИХХЯ/20250202007, "Харилцаа холбооны сүлжээ хүрээгүй алслагдсан багт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх (40 хүртэлх баг)" ЦХИХХЯ/20250103134, "Алслагдсан орон нутаг, сумын шуудангийн үйлчилгээний чанарыг сайжруулах, шуудангийн хяналт, бүртгэл, байршлын мэдээллээр хангах технологийн шийдэл, тоног төхөөрөмж нэвтрүүлэх (182 сум)" ЦХИХХЯ/20250102010, "Үүрэн холбооны үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор эрчим хүчний саатал ихтэй алслагдсан багт байрших бааз станцын нөөц тэжээлийн эх үүсвэрийг шинэчлэх (10 сайт)" ЦХИХХЯ/20250102009 дугаартай төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 сарын 26-ны өдрийн А/45 дугаартай тушаалаар байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулж, нийт 7 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг	01-06 сар	90%
--	--	--	---	---	---	-----------	-----

					цахим системээр зохион байгуулж, тендер хянан үзэх, үнэлэх үнэлгээний хороог төсөл арга хэмжээ тус бүрээр хуралдуулж, үр дүнг цахим системд нийтэлж ажилласан.		
Дэд арга хэмжээ - 1.1.3. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулах, батлуулах.	Батлуулсан техникийн тодорхойлолтын тоо	0	8	“Сангийн хөрөнгөөр сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргах”, “Харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ хүрээгүй хүн ам, газар нутгийн талаарх зах зээлийн нөхцөл байдлын судалгааг хийлгэх”, “Харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг алслагдсан бүс нутагт турших, нэвтрүүлэхэд шаардлагатай нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмж (30 цэг)”, “Харилцаа холбооны сүлжээ хүрээгүй алслагдсан багт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх (40 хүртэлх баг)”, “Алслагдсан орон нутаг, сумын шуудангийн үйлчилгээний чанарыг сайжруулах, шуудангийн хяналт, бүртгэл, байршлын мэдээллээр хангах технологийн шийдэл, тоног төхөөрөмж нэвтрүүлэх (182 сум)”, “Үүрэн холбооны үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор эрчим хүчний саатал ихтэй алслагдсан багт байрших бааз станцын нөөц тэжээлийн эх үүсвэрийг шинэчлэх (10 сайт)” төслийн техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, багцад задлах тушаалын төслийг боловсруулж, батлуулсан.	01-06 сар	90%	
Дэд арга хэмжээ - 1.1.4. Тендер, сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах, төслийн гүйцэтгэлийг хянах, шалгах.	Байгуулсан гэрээ, санхүүжилт олгосон төслийн тоо	2	8	“Сангийн хөрөнгөөр сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргах” ЦХИХХЯ/20250203003 дугаартай гэрээг 2025 оны 05 сарын 30-ны өдөр “Вай инсайт” ХХК-тай, “Харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ хүрээгүй хүн ам, газар нутгийн талаарх зах зээлийн нөхцөл байдлын судалгааг хийлгэх” ЦХИХХЯ/20250203004 дугаартай гэрээг 2025 оны 05 сарын 29-ний өдөр “Вай инсайт” ХХК-тай,	01-06 сар	90%	

					“Харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг алслагдсан бүс нутагт турших, нэвтрүүлэхэд шаардлагатай нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмж (30 цэг)” ЦХИХХЯ/20250202007 дугаартай гэрээг 2025 оны сарын өдөр “Парламентын суваг” ХХК-тай, “Харилцаа холбооны сүлжээ хүрээгүй алслагдсан багт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх (40 хүртэлх баг)” ЦХИХХЯ/20250103134 дугаартай төслийн “багц 1”, “багц 2”, “багц 5”-ын гэрээг “Мобиком корпораци” ХХК-тай 2025 оны 05 сарын 15-ны өдөр, “багц 4” гэрээг “Скайтел” ХХК-тай 2025 оны 05 сарын 15-ны өдөр, “Алслагдсан орон нутаг, сумын шуудангийн үйлчилгээний чанарыг сайжруулах, шуудангийн хяналт, бүртгэл, байршлын мэдээллээр хангах технологийн шийдэл, тоног төхөөрөмж нэвтрүүлэх (182 сум)” ЦХИХХЯ/202501020102025 дугаартай гэрээг 2025 оны 05 сарын 15-ны өдөр “Инфосолюшн” ХХК-тай, “Үүрэн холбооны үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор эрчим хүчний саатал ихтэй алслагдсан багт байрших бааз станцын нөөц тэжээлийн эх үүсвэрийг шинэчлэх (10 сайт)” ЦХИХХЯ/20250102009 дугаартай дугаартай гэрээг 2025 оны 05 сарын 15-ны өдөр “Ногоон үйлс” ХХК-тай тус тус байгуулж, төслийн хэрэгжилтийг зохион байгуулж байна.		
Дэд арга хэмжээ - 1.1.5. Шинэ болон шилжих төсөл, арга хэмжээний санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн материалыг холбогдох журмын дагуу хянах, гэрээг дүгнэх, санхүүжилт олгох	Санхүүжилтийн гүйцэтгэл хянасан, санхүүжилт олгосон тоо	2	10	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ”-ний хүрээнд шилжих төсөл болох “Хэт богино долгионы дахин дамжуулах станцын хамрах хүрээг нэмэгдүүлэх, өргөтгөх, ЦХХХЯ/20240202160” дугаартай гэрээний гүйцэтгэгч “Фэйд трий” ХХК-ийн ирүүлсэн гүйцэтгэлийн баримт материалыг хянан баталгаажуулж, гэрээг дүгнэж, 40,988,640 төгрөгийн санхүүжилт олгох асуудлыг Хөрөнгө	01-06 сар	10%	

	асуудлыг шийдвэрлүүлэх.				оруулалт, санхүүгийн хэлтсээр эцэслэн шийдвэрлүүлсэн. 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан бусад төсөл арга хэмжээний санхүүжилтийн тайлант хугацаа болоогүй, гүйцэтгэгч байгууллагуудаас санхүүжилт хүссэн баримт материал, гүйцэтгэлийн тайланг хараахан ирүүлээгүй байна.		
	Арга хэмжээ - 1.2. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэх ажлыг зохион байгуулах, хяналтын зөвлөлөөр хэлэлцүүлэх.	Ирүүлсэн санал, хурал зохион байгуулсан тоо	0	0	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд санал авахаар 21 аймгийн Засаг дарга, Харилцаа холбооны зохицуулах хороо, Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци ГҮТББ, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК болон үүрэн холбоо, шуудан, цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад 2025 оны 05 сарын 21-ний өдрийн 02/1219, 02/1231 дугаартай албан бичгээр тус тус илгээж, шаардлагатай мэдээллийг утсаар холбогдон өгч, саналыг хүлээн авч байна. Хяналтын зөвлөлийн хурлыг Засгийн газрын 2023 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам"-ын 6.1 дэх хэсэгт заасны дагуу, саналын нэгтгэлд үндэслэн зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	01-06 сар	50%
Зорилт 2. Шуудан, радио, өргөн нэвтрүүлгийн салбарт гарч байгаа шинэ техник, технологийг нэвтрүүлэх, шуудангийн үндсэн сүлжээг төрийн дэмжлэгтэйгээр хувийн хэвшилд тулгуурлан өргөтгөн хөгжүүлэх, хэрэгжүүлэх, шуудангийн нэгдсэн кодыг олон нийтэд таниулах, хэрэглээнд нэвтрүүлнэ.							
1.	Арга хэмжээ - 2.1. Шуудангийн нэгдсэн код оноох аргачлалыг шинэчлэн	Батлуулсан баримт бичгийн тоо	0	0	Тайлант хугацаа болоогүй.	01-06 сар	0%

	боловсруулах, батлуулах.						
	Арга хэмжээ - 2.2. Дэлхийн шуудан холбооны Ази Номхон далайн бүс нутгийн холбооны Гүйцэтгэх зөвлөлийн хурал (Executive Council Meeting)-ыг Монгол Улсад зохион байгуулах.	Арга хэмжээний тоо	0	0	Тайлант хугацаа болоогүй.	01-06 сар	0%
	Арга хэмжээ - 2.3. Хаягжилтын тухай хуулийн төсөлд санал боловсруулж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэх.	Хүргүүлсэн хуулийн төслийн тоо	0	0	Тайлант хугацаа болоогүй.	01-06 сар	0%
Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”							
1.	Арга хэмжээ - 3.1. Яамны дотоод болон бусад байгууллагаас байгуулсан ажлын хэсэг, үнэлгээний хороонд ажиллах.	Ажлын хэсэг, үнэлгээний хорооны тоо	0	Тухай бүр	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 сарын 28-ны өдрийн А/102 дугаартай тушаалаар байгуулсан “Шуудангийн салбарын бодлогыг боловсронгуй болгох суурь судалгаа, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах, хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах” төслийн үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар, мөн 2025 оны 05 сарын 20-ны өдрийн А/155 дугаартай тушаалаар байгуулсан “Харилцаа холбооны салбарын (мобайл станц, шилэн кабель, шуудан) нэгдсэн дата бааз байгуулах, real time AI-д суурилсан систем үүсгэх” төслийн үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж, холбогдох тендерийг зохион байгуулан ажиллаж байна.	01-06 сар	50%

2	Арга хэмжээ - 3.2. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	ХАСХОМ бөглөх болон хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан баримтын тоо	0	Тухай бүр	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд бөглөж, 2025 оны 02 сарын 11-ний өдөр, 2025 оны 05 сарын 08-ны өдөр тус тус баталгаажуулсан.	01-06 сар	100%
3	Арга хэмжээ - 3.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнах.	Төлөвлөгөө, тайлангийн тоо	0	Тухай бүр	2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.	01-06 сар	100%
4	Арга хэмжээ - 3.4. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, аудитын шалгалт болон бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний биелэлт, тэдгээрийн хэрэгжилт, бусад шаардлагатай тоо баримт, мэдээлэл, тайлбарыг тогтоосон хугацаанд гаргаж,	Хэрэгжилтийн тайлан хүргүүлсэн эсэх	0	Тухай бүр	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг тухайд нь холбогдох байгууллага, албан тушаалтанд гарган өгч ажиллаж байна.	01-06 сар	0%

	танилцаж, хариу хүргүүлэх.						
6	Арга хэмжээ - 3.6. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх.	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн тоо	0	Тухай бүр		01-06 сар	0%
7	Арга хэмжээ - 3.7. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлах.	Архивд хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо	0	Тухай бүр	Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл гэрээний дагуу хийгдэж байгаа тул баримт материалыг архив-т шилжүүлээгүй байна.	01-06 сар	0%


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ - 1. Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтад хамрагдах.	Хамрагдсан сургалтын тоо	3	4	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох АЗ сургалтад хамрагдаж, 2025/1611 дугаартай гэрчилгээг 2025 оны 04 сарын 04-ний өдөр хүлээж авсан.	01-06 сар	100%

2	Арга хэмжээ - 2. Төрийн албаны сургууль, Удирдлагын академийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоо	1	1	Удирдлагын академиас зохион байгуулсан Төрийн албанд томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдаж, нийт 13 багц цагийн хичээл судалж, 2025 оны 02 сарын 25-ны өдрийн N1751 сертификаттай төгссөн.	01-06 сар	100%
3	Арга хэмжээ - 4. Төрийн худалдан авах ажиллагаа, салбарт хамаарах хууль, тогтоомжтой тогтмол танилцах, хэрэгжүүлэх.	Уншиж танилцсан хууль тогтоомжийн тоо	0	3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга (2023 оны 06 сарын 16-ны өдөр), холбогдох журам, тендерийн жишиг баримтууд, Засгийн газрын 2023 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам” болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-тай тогтмол танилцаж, тэдгээрийг гүйцэтгэлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.	01-06 сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан,
шуудангийн зохицуулалт хариуцсан
ахлах мэргэжилтэн
(Албан тушаал)

Ш.САМДАНЖАМЦ /  /

(Нэр, гарын үсэг)

2025 оны сарын-ны өдөр

(Огноо)